

ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР: /2022 он/

НЭГ: Батлан гаргасан хөгжлийн бодлогын баримт бичгүүд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 60 тоот тогтоолоор “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээг батлууллаа.
2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 121 тоот тогтоолоор “Чадварлаг багш” арга хэмжээг батлууллаа.
3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 88 тоот тогтоолоор “Сэлэнгэ аймгийн боловсролыг 2022-2032 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г батлууллаа.
4. Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/177 тоот захирамжаар “Үндэсний бичигтэн 2022-2024” хөдөлгөөн” арга хэмжээг батлууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар:

1. “Корона вируст халдварт “Covid-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх ажлын явц, үр дүн”,
2. “Сүрьеэгүй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай,
3. “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээний явц үр дүн,
4. “Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежуудын үйл ажиллагааны явц, үр дүн”,
5. “Спортлог Сэлэнгэчүүд” арга хэмжээний явц үр дүн,
6. “Өсвөрийн шигшээ багийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”,
7. “Соёл урлаг хүний хөгжилд” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн,
8. “Залууст боломж” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц үр дүн,
9. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын талаар авч хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний явц үр дүн”,
10. “Бид Сэлэнгийн ирээдүй” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц үр дүн,
11. “Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ажлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”,
12. “Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”,
13. “Хүүхдийн ордон, хүүхэд хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”,

14. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”,
15. “Ахмад настан, эмэгтэйчүүдийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”,
16. “Халамжаас-Хөдөлмөрт” иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын явц, үр дүнгийн мэдээллийг хэлэлцүүлсэн.

ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ:

1. Ковидын эмчилгээний тасагт дайчлагдан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нөөцийг бүрдүүлэн, давхардсан тоогоор 624 эрүүл мэндийн ажилтнуудыг хамрууллаа.
2. Коронавирусын цар тахалын улмаас Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр **“Коронавирусын халдварын дараах хяналтын үзлэг”**-ийг Хушаат, Хүдэр Түшиг, Цагааннуур суманд зохион байгуулсан.
3. Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр 59 насанд хүрэгч, 231 хүүхэд зөвлөх үйлчилгээг үзүүлж, Залуучууд хөгжлийн төвийг түшиглэн амьдрах ухааны 12 модуль сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж давхардсан тоогоор 1016 иргэн хамрагдсан байна.
4. Хүүхэд хөгжлийн 3 төвөөр дамжуулан 21 төрлийн дугуйланд 2726 хүүхэд, өсвөр насны хүүхдүүдийн дунд 5 төрлийн цахим уралдааныг зохион байгууллаа.
5. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, Сэлэнгэ аймаг хоорондын хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын БНБУ-ын Улаан-Үүд хотод байрлах Цөмийн оношилгооны төвийн үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг зохион байгууллаа.
6. Хавдар судлалын үндэсний төв, Улсын клиникийн 1-р эмнэлэг АШУҮИС-тай хамтран ажиллах гэрээг байгууллаа.
7. Дезерет олон улсын энэрлийн байгууллагатай хамтран эрүүл мэндийн бүх байгууллагуудад тоног төхөөрөмжийг нийлүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.
8. Улаанбаатар хотын “Бундан” НҮТББ ” ХЯЗГААРААС ЧИНАД” төслийн багийнхан зүрхний төрөлхийн болон олдмол эмгэгтэй хүүхэд, насанд хүргэгчдэд амьдрал бэлэглэх нийгмийн хариуцлагын хүрээн дэхь төслийг Мандал суманд хэрэгжүүлж, 714 иргэнийг үзлэгт хамруулж, зүрхний мэс заслын хагалгаанд орох шаардлагатай 38 иргэнд тусламж үзүүллээ.
9. “Эрүүл-шүд” хүүхдийн шүдний өвчлөлийг эрт илрүүлэн, эмчлэх үзлэгийг явуулын хэлбэрээр зохион байгууллаа.
10. Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын чанарын гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээг зохион байгууллаа.
11. “Оны улсын шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурал” зохион байгууллаа.
12. ОХУ-ын Бүгд найрамдах Буриадын Улстай хамтран ажиллах гэрээний хүрээнд Сүхбаатар сумын 1 дүгээр сургуульд Орос хэлний төвийг нээх ажлыг зохион байгууллаа.

13. Аймгийн Засаг даргын дэмжлэгээр аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран зохион байгуулсан “Дохионы хэлний” анхан шатны сургалтад багш нараа хамрууллаа.
14. “Багш нарын спорт, урлагийн наадам” зохион байгуулж, 35 сургууль, 43 цэцэрлэгийн багш, ажилтнууд ур чадвараараа өрсөлдлөө.
15. Ерөнхий боловсролын 30 сургуулийг биологийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, 31 сургуульд технологийн хичээлийн кабинетын тоног төхөөрөмжийг гардуулах арга хэмжээг зохион байгууллаа
16. БНСУ-ын Жэжү тусгай мужийн Боловсролын газраас Цагааннуур сумын сургуульд орчин үеийн мэдээлэл харилцааны технологийн кабинетийг тохижуулан хүлээлгэнэгөх арга хэмжээг зохион байгууллаа.
17. Иргэдийн инновацийн санаачилгыг дэмжих “Мон X” хөтөлбөрийг сурталчлах ажлыг сум, тосгодод зохион байгууллаа.
18. Насан туршийн боловсрол төвд ДЗМОУБ-ын “Сэлэнгэ хөгжлийн хөтөлбөр”-ийн хөрөнгө оруулалтаар “Коридорын номын сан”-г шинээр байгууллаа.
19. “Мобиком” компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд “Сэлэнгэ” мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд Япон улсын “Juki”брендийн оёдолын машин сургалтын хэрэглэгдэхүүнийг хүлээлгэн хүлээлгэнэгөх арга хэмжээг зохион байгууллаа
20. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд нь сургалтын орчин, дадлагын газар, чадамжийн төвийг иргэд олон нийтэд танилцуулах, уралдаан тэмцээнд оролцох, суралцагч төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг сурталчлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүтээлийн үзэсгэлэн худалдаа, туршлага түгээн дэлгэрүүлэх, ажил олгогчийн хамтын ажиллагаа өргөжүүлэх, ажлын байранд зуучлах, элсэлт нэмэгдүүлэх чиглэлээр олон уулзалт хэлэлцүүлэг, сургалтын арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд 29 багшийг төрийн албан хаагчийн болон дотуур байранд суулгаж, байраар ханган тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлж гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн үр дүнгээр манай аймгийн боловсролын салбар улсын хэмжээнд III байранд шалгарсан амжилтыг үзүүллээ.

Монгол улсын “Гавьяат багш”-аар Мандал сумын ахмад багш Б.Уунай тодорч, 4 багш Монгол улсын “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэгтэй боллоо.

Биеийн тамир, спорт:

1.7 сум,1 тосгон орон тооны арга зүйчтэй боллоо. Монгол орон даяар зохион байгуулсан “Эрүүл мэндийн цахим гүйлт-2022”, “4 аймаг 400 км” үзэл санааны явган алхалт арга хэмжээнд 480 гаруй иргэн хамрагдаж нийт 4000 гаруй км замыг туулсан бол монголын тамирчидаа алдаршуулах, Ардын хувьсгалын өлгий Сэлэнгэ-100мкм 3 өдөр, 2 шөнийн явган алхалтыг аймагтаа амжилттай зохион байгууллаа.

2.“Covid-19” цар тахлын улмаас улсын чанартай онлайн болон улсын аварга шалгаруулах 5 тэмцээнд 43 тамирчин оролцож 21 медаль хүртэж, олон улсын хэмжээний

мастер 1, спортын мастер 2, спортын дэд мастер 12, 1-р зэргийн тамирчин 141 төрөн гарсан.

3.Улс орон даяар зэрэг явагдах Иргэдийн наадам, Эрүүл иргэн-эртэч Монгол аян, аймгийн хэмжээнд “Жингийн илүүдэлгүй- эртэч Сэлэнгэчүүд” аян, Ахмадын баярыг угтсан арга хэмжээний аян, Цасны баяр, бүх нийтийн гүйлт, өдөрлөг, нэрэмжит тэмцээн, өртөөт марафон, аялал, аян зэрэг олон төрлөөр үйл ажиллагааг явуулж 14 зорилтот арга хэмжээнүүдэд 11200,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж аймгийн хэмжээний 70448 хүнийг татан оролцууллаа.

4.Ардын хувьсгалын 101 жилийн ойн Үндэсний их баяр наадмын хүчит бөхийн барилдаанд 1024 бөх барилдсанаас Цагааннуур сумын харьяат Таван хан дэвжээний бөх МУ-ын харцага Б.Орхонбаяр уран мэх хурд хүчээ гайхуулан барилдаж Сэлэнгэ нутаг шинэ арслан цолтонтой боллоо.

5.Улсын аварга шалгаруулах тэмцээнийг будаа зохион байгуулж, 4000 гаруй тамирчдыг орон нутагтаа хүлээн авч, баг тамирчид улсын аварга шалгаруулах 7 тэмцээнд тэргүүлж, аймгаараа “Эрүүл хөдөлгөөн”-д нэгдэж, аймгийн Засаг даргын нэрэмжит тэмцээний хүрээ өргөжилөө.

6.Спортын 173 төрлийн секц дугуйланд давхардсан тоогоор 3400 хүүхэд хичээллэж, 8 цогцолборордонд биеийн тамир спортын 72 төрлийн үйлчилгээг явуулан 70448 хүнд үйлчиллээ.

7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шатар, даамны улсын аваргад 6 тамирчныг оролцуулснаас Анхзаяа даам, С.Сундуй шатарын тэмцээнд тэтгүүн байрт шалгарч, С.Сундуй Ази тивийн “Цагаан таягтан”-ы наадмаас мөнгөн медаль хүртлээ.

8.Хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын Монголын бүх ард түмний 15 дугаар наадмын паражудо бөхийн төрөлд 2 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж багаараа тэргүүн байранд шалгарлаа.

9.Өсвөрийн хоккейн тамирчид, Волейболын идэрчүүд тус бүр улсын аварга болж, Сагсан бөмбөгийн U-15 насны тамирчид хүрэл медаль хүртлээ. Сүхбаатар аймагт болсон уулын дугуйн улсын аварга шалгаруулах тэмцээнд дугуйн спортын клуб холбоодын 13 тамирчдыг оролцуулж, 4 тамирчин улсын нэгдсэн зэрэг цолыг хамгааллаа.

10.Алтанбулаг суманд спортын цогцолбор, Мандал суманд соёл, амралт, биеийн тамирын иж бүрэн талбай, ХААН банкны хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сум, Мандал суманд 3 х3 сагсан бөмбөгийн стандартын талбайг ашиглалтанд оруулж, Баянгол, Цагааннуур, Ерөө спортын цогцолборууд, Спортын ордоны ашиглалтыг сайжруулах чиглэлээр урсгал засварын ажлыг 730.0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүрэн хийлээ.Баянгол, Сайхан сумын спорт цогцолбор тоног төхөөрөмжөөр, Алтанбулаг сум, Дулаанхан тосгоны спорт цогцолборыг 2 ком, ширээ сандалаар хангалаа.

Соёл, урлаг

Шинээр Соёл урлагийн газрыг байгуулж байраар ханган ажиллах орчин нөхцөлийг нь бүрдүүлсэн.

1.Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Бүгд Найрамдах Энэтхэг улсын Элчин сайд М.П.Сингх нар Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейд зочилж, виртуал музей болгох хөрөнгийг шийдвэрлэхээр боллоо. Нэгдсэн музейн зочилж, ажилтнуудыг IT инженерээр мэргэшүүлэх, музейн үзмэрийг виртуал болгох хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангахаар боллоо.

2.Соёлын яамтай хамтран соёл урлагийн байгууллагуудын менежментийн чадавхийг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

3.“Чандмань” циркийн жүжигчдийн тоглолт, цэцэрлэг, сургуулийн суралцагчдын дунд цахим орчинд үндэсний хэл бичгийн хэрэглээний соёлыг сурталчлах аян, “Соёлын үйлчилгээ-таны дэргэд”, Монгол хөөмий, уртын дууны сургалтад суралцагчдын дунд зохион байгуулагдсан “Монгол бахархал” гала тоглолт, “Цагаан эсгийн зан үйлийн үзүүлбэр тоглолт”, “Наурыз-2022”, “Буриад дууг хэн сайн дуулах вэ?” зэрэг хүүхэд, багачуудад зориулсан 70 гаруй цахим арга хэмжээг зохион байгууллаа.

4.“Ишигхэн ба түүний найзууд” хүүхдийн жүжиг, “Нүүдэлчин” Дэлхийн Соёлын Фестивальд оролцсон урлагийн тоглолт зэрэг хүүхэд багачуудын дунд зохион байгуулсан 10 гаруй уралдаан, баримтжуулалт бичлэг, нэвтрүүлэг, контент, видео шторкыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан түгээн дэлгэрүүлж нийт 88100 иргэнд үйлчиллээ.

5.17 сум 6 тосгонд “Соёлын орон зай” уулзалт, хэлэлцүүлэг, үзэсгэлэн, зөвлөгөөн зэрэг 30 арга хэмжээнд 1000 гаруй иргэд, соёлын үйлдвэрлэгчид хамрагдсан.

6.МҮОНРТ-тэй хамтран “Ардын хувьсгал-Алтанбулагаас эхтэй” зохиомжит нэвтрүүлэг, МҮОНРТ, Улсын дуурь бүжгийн эрдмийн театртай хамтран “Шивээ хиагт” дуурийг телевизийн бүтээл болгох уран бүтээлд уран бүтээлчид амжилттай оролцлоо.

7.Хөгжмийн нэрт зохиолч, найрал дууны удирдаач Гончигдамбын Дарамзагд агсны мэндэлсний 90 жилийн ойд зориулсан “Олон улсын мэргэжлийн дуулаачдын IV уралдаан”-д Сэлэнгийн Долгио чуулгын гоцлол дуучин МУСТА Ч.Өрнөхбаяр 2-р шатанд шалгарч, шилдэг 25 дуучны нэгээр шалгарлаа.

8.Төрийн хошой шагналт Ч.Лодойдамбын нэрэмжит “Алтай” чуулгаас орон нутгийн театр чуулгуудын дуучдын дунд зохион байгуулсан “Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн М.Норсонжавын дууг хэн сайн дуулах вэ?” улсын уралдаанд Сэлэнгийн Долгио чуулгын дуучин Ж.Оюундэлгэр Тэргүүн байр эзэлсэн.

9.Соёлын яам, Монголын урлагийн ажилтны холбооноос зохион байгуулсан “ШИЛДЭГ БҮТЭЭЛ-ШИЛДЭГ УРАН БҮТЭЭЛЧ” төв, орон нутгийн мэргэжлийн чуулгуудын уралдаант наадамд Ардын дуубүжгийн “Сэлэнгийн долгио” чуулга, Дуу бүжгийн “Мөнгөн хараа” чуулгын уран бүтээлчид шилдэг найруулагч,хөгжмийн зохиолч, зураач, бүжиг дэглээч, гоцлол дуучин уран бүтээлийн номинацийн шагналын эзэд боллоо.

10.Монголын Үндэсний номын сангаас Шилдэг нийтийн номын сан шалгаруулах уралдаанд 21 аймгийн нийтийн номын сангуудаас 2021 онд “Шилдэг нийтийн номын сан”-аар шалгарч өргөмжлөлийн эзэн болсон.

11.“Сэлэнгэ” МСҮТ, Шаамар сумын МСҮТ-ийн номын санг стандартыг хангасан “Бүс нутгийн загвар номын сан” болголоо.

12.Хүүхэд залуусын заавал мэдэх “Шүлгийн цахим уралдаан”-ыг зохион байгуулж, 200 гаруй хүүхэд багачуудыг хамрууллаа.

13.Соёлын баримтат өвийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, Хилийн 0243-р ангид хадгалагдаж байгаа н.Цэдэн-Иш генералын Монгол улсын хил тогтоох үед хөтөлж байсан тэмдэглэлийн дэвтэр, тухайн үеийн газрын зургийг баримтат өвд бүртгэн авч батламж гардууллаа.

14.Аймгийн хэмжээнд 300 гаруй соёлын биет бус өвлөн уламжлагчдыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлж, шавь сургалтыг аймгийн хэмжээнд 36 удаа зохион байгуулагдсан. Соёлын биет болон биет бус өвийг уламжлагч 61 иргэнийг цахим хуудсаар олон нийтэд алдаршууллаа.

15.“Сүхбаатарын туг” сонины 1961-1990 оны 2053 дугаарыг цахим программд орууллаа.

16.Монгол түмний гайхамшигт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх, сурталчлан таниулах зорилго бүхий “Нүүдэлчин Монгол-2022” их наадамд аймгийнхаа 61 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарыг уртын дуу, хотон бий биелгээ, цуур, икэл хуур, хуучир, гар урлал, хайчилбар, уран бичлэг, уран нугаралт зэрэг төрлөөр амжилттай оролцууллаа.

17.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хадгалалт хамгаалалтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, 3237 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг тоолон мэдээллийн баяжилтыг хийлээ.

18.Аймгийн хэмжээнд “Үндэсний бичигтэн 2022-2024” хөдөлгөөнийг өрнүүлж, байгууллага бүрт үндэсний бичгээ эрхэмлэндээдлэх, сурч судлах ажлыг эхлүүлээ. Үндэсний бичгийн 16 удаагийн сургалт, 22 удаагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, 336 иргэдийг түвшин ахиулах сургалтад хамруулж унших, бичих чадварыг нэмэгдүүлснээр үндэсний бичиг үсэг сурсан төрийн албан хаагч, иргэдийн эзлэх хувийг 40.6 хувьд хүргэлээ.

19.Сүхбаатар сумын 4, Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгүүд орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Гэр өргөө”-г ашиглалтад оруулснаар аймгийн хэмжээнд 9 сургууль, 19 цэцэрлэг “Монгол гэр өргөө”-тэй болж нүүдэлчин өв соёл уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, сургалт үйл ажиллагааг явуулах боломж бүрдлээ.

20.Ардын хувьсгалын 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жил, Ахмадын холбооны 90 жилийн ойг угтан Аймгийн ахмадын хорооноос санаачилж, “Бүрээчин” хөшөө, Партизаны хөшөөг сэргээн засварлаж хүлээлгэн өглөө.

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого:

1.Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллага, Европын Холбоо Швейцарын Хөгжлийн Агентлагийн хамтарсан 15.3 сая төгрөгийн санхүүжилтээр “Хүүхдийн бэлгийн хүчирхийллийг зогсооё” сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимыг шинээр нээлээ.

2.“Оролцоод хөгжье” хүүхдийн оролцооны IX чуулганыг цахимаар зохион байгуулж, 34 сургуулийн төлөөлөл 150 сурагч оролцож,хүүхдийн хөгжлийн талаарх санал бодлоо нэгтгэлээ.

3.Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын “Сэлэнгэ Нэгдсэн хөтөлбөр”-тэй хамтран сумдын 849 өрхөд тус бүр 100,000 төгрөгийн тусламж үзүүлсэн ба зорилтод

бүлгийн залуучуудад дэм болох тэдний төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор 9 удаагийн сайн үйлсийн аянг зарлаж, 245 өрхөд 27.0 сая төгрөгийн тусламж үзүүлжээ.

4.Нийт 1165 хүүхдэд хамгааллын үйлчилгээг үзүүллээ. Хорих ял эдэлж, суллагдсан 104залуучуудад зөвлөх үйлчилгээг үзүүллээ.

5.“Сэлэнгэ хүүхэд”, “Сэлэнгэ Залуучуудын хөгжлийн төв”, “Сэлэнгэ аймгийн сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ” пэйж хуудсуудаар дамжуулан “Хүчирхийллийн эсрэг Сэлэнгэчүүд хамтдаа” уриалгыг иргэд,олон нийтэд түгээлээ.

6.Зэвсэгт хүчний 100 жил, Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Залуучуудын хөгжлийн төв, “Залуучуудын эв нэгдэл” төрийн бус байгууллага, Ерөнхий боловсролын сургууль, Хилийн цэргийн 0243 дугаар ангитай хамтран “ЦЭРГИЙН НЭГ ӨДӨР” арга хэмжээг жил бүр зохион байгуулж, цэргийн амьдралын хэв маяг, цэрэг хүний тэсвэр тэвчээр түүний бахархал, мөн чанарыг олон нийтэд сурталчиллаа.

7.Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Шилдэг эцэг эхийн зөвлөл” шалгаруулах болзолт уралдаанд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар “Тэргүүн байр” эзэлсэн.

8.“Нэгдүгээрт хүүхэд” хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний чуулганд аймгаа төлөөлж оролцооны клубуудийн 7 гишүүд хамрагдсан.

9.“Хүүхдэд ээлтэй-Хүчирхийлэлгүй сум”, “Гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал” сэдэвт чадавхжуулах сургалтад 40 хамтарсан багийн 634гишүүдийг хамрууллаа.

10.ДЗМОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөр, Монголын асрамж, хамгаалал, нөхөн сэргээх төвүүдийн нэгдсэн холбоо ТББ-тай хамтран 14 сум, 2 тосгоны хамтарсан багийн үйл ажиллагаанд, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, “Шилдэг хамтарсан баг” -ийг шалгарууллаа.

11.Хүүхэд хамгааллын жишиг сургуулийг Мандал сумын ерөнхий боловсролын 2,4-р сургуулиудад туршиж байна.

12.Бага насны хүүхдүүдэд “Дэлгэцээс холдуулах дадлууд” номоор дамжуулан дэлгэцийн хор нөлөөг ойлгуулах, эрүүл зан үйлд төлөвшүүлэх зорилгоор “Дэлгэцийн донтолтоос сэргийлж эрүүл мэндээ хамгаалцгаая” аянг өрнүүлж дүгнэлээ.

13.16 сум, 5 тосгон, 50 төрийнболонтөрийнбусбайгууллагын 272 ажилтан алба хаагчдыг оролцуулсан байгууллага, ажахуйннэгжийндэргэдэх “ЭЦЭГ ЭХИЙН АНХДУГААР ЗӨВЛӨГӨӨН”-ийг зохион байгууллаа.

14.“Нэгдүгээрт хүүхэд” хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах хяналт шалгалтыг 17 сумын ерөнхий боловсролын 35 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 44 цэцэрлэгт явууллаа.

15.Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг 11 суманд байгуулан, залуучуудаа хөгжүүлж, чадвахжуулах ажлыг эхлүүлж, Пробононээлттэйхаалганыөдөрлөгийг зохион байгууллаа.

15.Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, хосын зөвлөгөөг 323 хүүхэд, 27 насанд хүрэгчдэд үзүүллээ.

16.“Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв”-ийн барилгын ажлыг гүйцэтгэж, 2023 онд ашиглалтад авна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал:

1.“Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлж, 13 багц үйлчилгээг цахимаар үзүүлж байна.

2.“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх Оролцоо” 2 үе шаттай хэрэгжих төсөлд 117 залуус бүртгүүлж, үүнээс 1 дүгээр үе шатанд 82 залуусыг сонгон авч, 14 хонгийн вакумжуулсан сургалтад хамруулан 41,0 сая төгрөгийн тэтгэлэг олгож, 2 дугаар шатанд 52 залуусыг сонгон авч, ажлын байрны дадлагад хамруулан 23.5 сая төгрөгийн тэтгэлэгт олгож, үүнээс 27 залуусыг нь байнгын ажлын байранд зуучиллаа.

3.2021 онд 1450 ажлын байрны захиалгад 1064 иргэнийг ажилд зуучилсан бол 2022 онд 1322 ажлын байранд 955 иргэнийг ажилд зуучилж ажилласан.

4.Баянгол, Хушаат, Бугант хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаггүй сум тосгон боллоо.

5.Шаамар сумын МСҮТ-ын 2 багш “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх” төслийн үндэсний хэмжээний чиглүүлэгч багшаар шалгарлаа.

6.ХНХЯ, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс зохион байгуулсан Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын “Инноваци шингэсэн бүтээлийн улсын уралдаан”-нд Шаамар сумын МСҮТ “Хэрэглэгчийн шаардлага хангасан бүтээл”-ийн номинацийн төрөлд: “Зөгийн балтай цэлцэгнүүр” бүтээлээрээ Тэргүүн байранд шалгарсан.

7.ХНХЯ болон Төвийн бүс хариуцсан арга зүйн албанаас багш, ажилтнуудын дунд зохион байгуулсан “Төвийн бүсийн шилдэг арга зүйтэй багш” уралдаанд Шаамар сумын МСҮТ-ын 1 багш 2-р байранд шалгарсан байна.

8.“Зүүнхараа” политехник коллеж Эрчимжсэн мал ахуйн фермер мэргэжлийн дадлагын стандартад нийцсэн фермерийн байр байгуулж, сургалтын дадлагын байрыг нэмэгдүүлсэн.

9.Хөгжлийн бэрхшээлтэй 83 иргэнийг “Бизнесээ эхлүүлье, хөгжүүлье” аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулан дэмжлэг үзүүлж, Сайхан, Мандал, Сант сумын иргэдийг тогооч, гоо засалч мэргэжлээр сургаж, хөгжлийн бэрхшээлтэй 8 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.

10.Хүн амын ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 онд 1150, 2022 онд 1210 ажлын байр бий болгож, өнгөрсөн оныхоос 9.5 хувиар ажлын байраар нэмэгдүүлсэн иргэдээ орлоготой, ажилтай болгож, эдийн засгийн өсөлт хөгжлийг дэмжих бодлогод ахиц гаргалаа.

11.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин “СЭЛЭНГЭ-СТАРТ-АП” арга хэмжээг зохион байгуулж, 2021-2022 онд 6 бүлэг шалгарч, тус бүр эргэн төлөх нөхцөлгүй 60.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэй болж гарааны бизнесээ эхлүүлээ.

17 сум 6 тосгоны мал аж ахуй, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, газар тариалан, ахуй үйлчилгээний чиглэлийн 51 төсөлд 400000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ.

12.Ахмадын зориулалттай амралт сувилалд 1387 ахмад настан 221570.0 мянган төгрөг, дотоодын рашаан сувилалд 851 ахмад настанд 113586.4 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олголоо.

13.Баянгол, Жавхлант, Зүүнбүрэн, Цагааннуур, Мандал, Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Сант сумдын 18 малчин өрхийгмалчдын санхүүгийн дэмжлэгт хамруулж,90000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр малжууллаа.

Тайлант хугацаанд 166 аж ахуй нэгж, байгууллагын 783 ажилтан, албан хаагчид Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажлын байран дахь осол гэмтлээс хэрхэн сэргийлэх тухай үзүүлэх сургалтыг 10 удаа зохион байгуулж ажиллалаа

14.Нийгмийн даатгалын санд цахим үйлчилгээ болон картжуулах үйлчилгээг нэвтрүүллээ.

15. “Нийгмийн даатгал” гар утасны аппликэйшнийг 21716 даатгуулагч идэвхтэй ашиглаж байгаа бөгөөд 2021 онд шинээр 3650 иргэн гар утасны аппликэйшинд бүртгүүлсэн байна.

16.2021онд малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч 338, 2022 онд 485 иргэн, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, оюутан 1042 иргэнийг 2021 онд хамруулсан бол 2022 онд 1533 иргэнийг хамрууллаа.

17.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах ажлыг иргэдэд аймгийн хэмжээнд 6 удаа зохион байгуулан 121 иргэнийг хамрууллаа

18.14 бүлгийн 28 өрхийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөл хөтөлбөрт хамруулж, 42 иргэнийг ажил, хөдөлмөр эрхэлж амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой болголоо.

19.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд нийт 921 иргэнийг хамруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5406.54 мянган төгрөг зарцуулсан байна.

20.Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 27 ахмад настанд 125000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож 27 ажлын байрыг шинээр бий болгосон

Тайлант хугацаанд Шинээр 1210 ажлын байр бий болгосон ба үүнээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй төсөл хөтөлбөр, жижиг зээлээр 153 байнгын ажлын байр, 322 түр ажлын байрбий болгон ажилласан.

21. 0-18 насны хүүхэд, өндөр насны тэтгэвэр авагч, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн гишүүн, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, хүүхдээ 2 болон ихэр бол 3 нас хүртэл өсгөж байгаа эх эсвэл эцэг, ял эдэлж байгаа ялтан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад ЭМД-ын сан 100 хувь хариуцдаг болсон.

22.Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусламж үйлчилгээнд олон улсын оношлогоо эмчилгээний “uptodate”платформын дагуу чанарын хяналт хийж чанарын шаардлага хангасан тусламж үйлчилгээний зардлыг олгодог болсноор иргэд даатгуулагчдад олон улсын стандартад нийцсэн чанартай тусламж үйлчилгээг үзүүлэх болсон.

23.Мөн Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг бодит цагийн горимоор хүлээн авдаг болсноор даатгуулагчийн тусламж үйлчилгээний давхцалыг арилгаж, шаардлагагүй оношлогоо шинжилгээ хийлгэх зэрэгт гарах эрүүл мэндийн даатгалын сангийн үргүй зардлыг багасгаж байна.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн чиглэлээр:

№	Зохион байгуулсан ажлууд	Оролцсон иргэдийн тоо
2022 онд зохион байгуулсан олон нийтийн ажлууд		
1.	Өвлийн хөтөлбөр	78
2.	Тоглонгоо уншъя	179
3.	Монгол тууль- Дэлхийн өв	3
4.	Дэлгэцтэй биш дэлгэсэн номтой нөхөрлөө	459
5.	Хооллох соёл- Ширээ засалт	15
6.	Үлгэрээр хүмүүжье чанга уншлага	489
7.	Дэлхийн хүүхдийн номын өдөр	30
8	Бид эх орны хөвгүүд	22
9.	Уншигчийн бага хурал	15
10	Үндэсний бичиг үсгийн баяр	650
11	Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2022 арга хэмжээ	401
12	Номын хотхон	900
13	Ном хож	62
14	Оюунлаг бүтээлч ирээдүйн төлөө уриатай “Зуны хөтөлбөр”	228
15	Эх хэлний өдөр	202
16	Номын сантай танилцах аялал	328
17	Хүүхдээ сонсоё аян	110
18	“Буудай ба Сарнай” Комик дүр	5
19	Зохиолч С.Молор- Эрдэнэ “Шинэ номын танилцуулга уулзалт	48
20	Номыг шинжихүй	77
21	Соёлын бүтээлч сар Үндэсний нэгдмэл үнэт зүйл	553
22	Соёлын бүтээлч сар Бүх нийтийн соёлын боловсрол	196
23	Соёлын бүтээлч сар Соёлын бүтээлч үйлдвэрлэл	43
24	“Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн сурагч болцгооё” аян	6635

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

25	Номын сангийн дэргэдэх номын клуб байгуулсан	25
26	Үлгэрч багачууд цахим уралдаан зохион байгуулсан	15
27	Номтой өглөө 30 минутын уншлага	198
28.	Өглөөний уншлага	98
29	“Зохист аялгуу-2022”	98
30	Улирлын шилдэг уншигч шалгаруулах	4
31	Соёлын бүтээлч сар аян хүрээнд Соёлын аялал жуулчлал	377

Нийгмийн салбарын чиглэлээр нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээлэл:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Е.Алтынай 7036-2150